

**НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ**

Д/д	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	<b>Нэр</b> Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Баянзүрх овгийн Батаагийн Баттулга.
2	<b>Хүсэлт гаргагчийн хаяг</b> Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	
3	<b>Төрсөн огноо</b> Төрсөн газар	
4	<b>Боловсрол</b> Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.	МУИС-д хууль зүйн магистр 1997-1998 он. МЛОИС-д улс төрийн дээд боловсрол 1987-1989 он. Лектор, суртал нэвтрүүлэгч МУИС-ийн НУФ-ийн Хууль зүйн анги 1980-1985 он хуульч, эрх зүйч.
5	<b>Ажил эрхлэлт</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	БОАЖЯ-ны харъяа ЦУОШГ-т дэд дарга. /БОАЖ сайдын тушаалаар./ Утас: 260943. 2015 оны 4-р сараас өнөөдрийг хүртэл. “Буд өргөө” ХХК-д зөвлөх 2013-2015 он. “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д хүний нөөцийн хэлтэсийн дарга. 2009-2013 он. Монгол улсын Сонгуулийн Ерөнхий хорооны дарга. 2006-2009 он Монгол Улсын шадар сайдын зөвлөх. 2004-2006 он. Монгол Улсын Их Хурлын гишүүн. 2000-2004 он. Дархан Уул аймгийн Засаг даргын тамгын газрын дарга. 1994-2000 он. Дархан хотын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга. 1990-1994 он. Дархан хотын өтөл хорооны АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны дарга. 1989-1990 он. Дархан хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанд байцаагч, мэргэжилтэн, зохион байгуулагч. 1985-1989 он.
6	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал</b> Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.	ХЭҮК-ийн гишүүн

7	<p><b>Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил</b>  Хүсэлт гарагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</li> <li>-ажлын байрны тодорхойлолт;</li> <li>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.</li> </ul>	
	<p><b>Ёс зүй</b>  Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> <li>-сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх;</li> <li>-сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх.</li> </ul>	<p>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байгаагүй.</p> <p>Сүүлийн 5 жилд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй.</p>
9	<p><b>Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар</b>  Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;</li> <li>-үйл ажиллагааны гол агуулга;</li> <li>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;</li> <li>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</li> </ul>	<p>2000-2004 онд УИХ-ын гишүүнээр сонгогдог ажиллаж байхдаа Хуулийн байгууллагуудын эрх зүйн үндэсийг шинэчлэн тогтоосон дараахь багц хуулиудын төслүүдийг болоюсруулах ажлын хэсэгт томилогдон ажиллаж УИХ-аар хэлэлцүүлэн батлуулж байсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Эрүүгийн хууль 2002 он</li> <li>Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002 он.</li> <li>Иргэний хууль 2002 он</li> <li>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он.</li> <li>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002 он</li> <li>Өмгөөллийн тухай хууль 2002 он</li> <li>Прокурорын тухай хууль 2002 он</li> <li>Цагдаагийн байгууллагын тухай хууль 2002 он</li> <li>Шүүхийн тухай хууль 2002 он</li> <li>Нотариатын тухай хууль</li> <li>Хуульч сонгон шалгаруулах тухай хууль</li> <li>Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай</li> <li>Монгол улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт</li> <li>Газрын тухай</li> <li>Архидан согтуурахтай тэмцэх тухай</li> <li>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай</li> <li>Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай</li> </ul>

		<p>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль          Прокурорын байгууллагын тухай хууль          Иргэний хэргийн тодорхой заалтууд Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг ҮХЦ-ийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэхэд УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажиллаж байлаа.</p>
10	<p><b>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил</b>          Хүсэлт гарагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:          -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;          -ажлын байрны тодорхойлолт;          -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;          -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.</p>	<p><b>“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хүний нөөцийн хэлтсийн дарга 2009-2013 он</b>          Хүний нөөцийн хэлтсийн даргын ажлын байрны тодорхойлолт ... мэргэжилтэй ажилчид, инженер, техникийн ажилтнуудыг сонгон шалгаруулж хөдөлмөрийн гэрээ байгуулах, мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлэх, ажиллах нөхцөл бололцоогоор хангах, ҮЭ ажил олгогч эздийн байгууллагуудтай 3 талт хэлэлцээр байгуулах эрүүл мэнд, нийгмийн хөтөлбөр хэрэгжүүлэх.  <b>СЕХ-ны дарга 2006-2009 он.</b>          Монгол улсын Үндсэн хуулинд ... Монгол улсын иргэд төрийг удирдах хэрэгт оролцох, төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй гэж заасан юм. СЕХ-д ажиллах хугацаандаа иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хууль зүйн хүрээнд бодитой эдлүүлэхэд онцгой анхаарч ажилласан.          УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулж явуулахын тулд сонгууль товлон зарлах, тойрог хэсэг байгуулах, бүрэлдхүүнийг батлах, сонгогчдын нэрсийн жагсаалтыг гаргах, нам, эвсэлүүд, бие даагчидтай ажиллах, нэр дэвшүүлэх, сурталчилгаа хийх, санал хураалт явуулах, сонгуулийн эцсийн дүн гаргах, олон нийтэд мэдээлэх, Ерөнхийлөгч, УИХ-д өргөн мэдүүлэх, бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрүүлэх зэрэг сонгуулийн бүх шатны үйл ажиллагааг хуулийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангаж зохион байгуулсан болно.  <b>УИХ-ын Гишүүн /2000-2004 он/</b>          Гишүүнээр сонгогдон ажиллах хугацаандаа хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр дараахь хуулиудын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдхүүнд ажиллаж УИХ-аар батлуулсан байна.          Эрүүгийн хууль.          Эрүүгийн байцаан шийтгэх хууль.          Иргэний хууль.          Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.          Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.          Өмгөөллийн тухай хууль.          Прокурорын тухай хууль.          Цагдаагийн байгууллагын тухай хууль.          Шүүхийн тухай хууль.          Нотариатын тухай хууль.          Хуульч сонгон шалгаруулах тухай хууль          Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай          Монгол улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт          Газрын тухай хууль          Архидан согтуурахтай тэмцэх тухай</p>

		<p>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль Прокурорын байгууллагын тухай хууль</p>
<p><b>11</b></p>	<p><b>Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал</b> Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</p>	<p>1. Агаарын чанарын хяналт, мониторингийн ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж байна. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 15 автомат станцаар байнга хянаж иргэдэд тогтмол мэдээлж байна. 2019 оны агаарын бохирдлын хэмжээг 2016 онтой харьцуулахад РМ 2,5 тоосонцор 56%, РМ 10 тоосонцор 50 % тус тус буурсан дүнтэй байна.</p> <p>2. БОАЖ сайдын өгсөн үүрэг, даалгаварын дагуу агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явууллаа. Монгол улсын хэмжээнд төрөл бүрийн түлш шатаадаг ердийн галлагаатай зуух 389550, уурын болон усан халаалттай зуух 6638, авто тээврийн хэрэгсэл 1043028 бүртгэгдсэн байна. Энэ эх үүсвэрүүдийн 70 орчим хувь нь зөвхөн нийслэл Улаанбаатар хотод оногдож байна. Дээрхи зуухнууд нийтдээ 8,8 сая тонн түүхий нүүрс, 271210 тн сайжруулсан түлш, 1,3 сая м<sup>3</sup> түлээний мод шатаасан байна.</p> <p>3. Монгол улсын хэмжээнд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна. Бүх аймаг, нийслэлийн хэмжээнд 45 хөдөлгөөнт экспедиц, 39 газрын генератор, 4 явуулын, 1 суурин радар ажиллаж байна. Хавар, намрын улиралд хуурайшилтаас шалтгаалж ой хээрийн түймэр гарах тоо давтамж нэмэгдсээр байна. Зөвхөн өнгөрсөн онд Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Хөвсгөл, Дорнод аймаг, Улаанбаатар хотын бүс нутагт 9 экспедиц 68 удаа ажиллаж дээрхи аймгуудын нутаг дэвсгэрт асаж байсан хүний хүч мөхөстсөн 34 түймрийн голомтыг цаг агаарт зориудаар нөлөөлж унтраасан байна.</p> <p>4. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах боломжийн талаар Цаг уур, орчины судалгаа, мэдээлэлийн хүрээлэнгийн эрдэмтэдтэй хамтран судалгаанспиы ажил хийж байна.</p> <p>5. Хур тунадас нэмэгдүүлэх зорилгоор газар тариалангийн бүс нутаг Сэлэнгэ аймагт 4, Төв аймагт 3, Булган, Хөвсгөл, Хэнтий аймгуудад тус бүр 2, Дархан Уул, Орхон, Улаанбаатар хотод тус бүр 1 экспедиц ажиллуулж 70 гаруй удаа цаг агаарт зориудаар нөлөөлсөний үр дүнд үр тариа, төмс, хүнсний ногооны ургац жилээс жилд нэмэгдсээр байна.</p> <p>6. 2008 оны УИХ-ын сонгуулийг хуулиар олгогдсон эрх, үүргийн дагуу удирдан зохион байгуулж сонгуулийн эцсийн дүнг нэгтгэн сонгогчидод танилцуулж, Монгол улсын ерөнхийлөгчид айлтган УИХ-ын даргад өргөн мэдүүлж шинэ гишүүдийн бүрэн эрхийг УИХ-аар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулсан юм.</p> <p>7. Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх зорилгоор НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр Фридрих Эбертийн сан зэрэг ТББ-тай хамтран иргэн хүн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхээ идэвхтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн телевиз, радиогийн цуврал ярилцлагуудыг зохион байгуулж байлаа.</p> <p>8. 2008 оны орон нутгийн ИТХ-ыг сонгох сонгуулийг хуулийн дагуу удирдан зохион байгуулж 21 аймаг, нийслэлийн ИТХ, засаг дарга нарыг сонгож, томилуулах хууль эрх зүйн нөхцөлийг бүрдүүлж байлаа.</p>

		<p>9. Эрдэнэт үйлдвэрийн сул ажлын байрыг нээлттэй зарлаж, сонгон шалгаруулдаг журамд шилжүүлэв. Ингэснээр хээл хахууль авч ажилд оруулдаг гэсэн олон жилийн шүүмжлэлд цэг тавьж нээлттэй чөлөөтэй өрсөлддөг зах зээлийн зарчимд шилжүүлсэн юм.</p> <p>10. Монголчууд олон зуун мянган доллар зарцуулж гадаадад оношилгоо эмчилгээнд явдаг байсан. Энэ асуудлыг шийдвэрлэх алхам хийх зорилгоор Эрдэнэт үйлдлвэр Оношилгоо, эмчилгээний олон улсын жишигт хүрсэн төвийг байгуулсан юм. Энэ төвд ажиллах өндөр нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг боловсон хүчний бодлогын хүрээнд бэлтгэсэн юм. Одоо энэ төв олон нийтэд нээлттэй үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>11. Эрдэнэт үйлдвэрийн ажиллагсдын дунд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх замаар хөдөлгөөний хомсдолоос шалтгаалсан өвчлөлийг бууруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт” төсөл хэрэгжүүлсэн. Энэ төслийн үр дүнд 4 жилд 2500 гаруй ажилтан хамрагдаж спортын 16 төрлөөр хичээллэж өвчлөл 8,1 хувиар буурч хөдөлмөрийн бүтээмж 9,3 хувиар дээшилсэн юм.</p> <p>12. Эрдэнэт үйлдвэрийн хүний нөөцийн бодлого нь “Хөгжил дэвшил хүнээс эхлэнэ” гэсэн зарчимд тулгуурласан “Хүн эрдэнэ” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн юм. Энэ хөтөлбөр хэрэгжиж хувь хүн бүр өөрийгөө хөгжүүлж хүчээ нэгтгэсний үр дүнд Эрдэнэт үйлдвэр дэлхийн шилдэг үйлдвэр болсон юм.</p>
12	<p><b>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар</b>  Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:  -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;  -ажлын байрны тодорхойлолт;  -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;  -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл  <b>Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.</b></p>	
13	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b>  Монголын Хуульчдын холбоо, Монголын</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэл байхгүй болно.</p>

	<p>Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ.</p>	
14	<p><b>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</b></p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.</p> <p>-хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.</p> <p><b>Жич:</b> Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана.</p>	<p>Эрдэнэт үйлдвэр 2009 оноос эхлэн олон улсын жишигээр нийгмийн хариуцлагын тайлангаа гаргаж жил бүр тайлагнадаг болсон.</p> <p>Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагын тайлан 2009 он.</p> <p>Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагын тайлан 2010 он.</p> <p>Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагын тайлан 2011 он.</p> <p>Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагын тайлан 2012 он.</p> <p>Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагын тайлан 2013 он.</p> <p>Эрдэнэт үйлдвэрийн хүний нөөцийн бодлого, хөгжил дэвшил хүнээс эхлэнэ “Хүн эрдэнэ” хөтөлбөр 2011 он.</p> <p>Эрдэнэт үйлдвэрт хэрэгжиж байгаа хөдөлмөр, нийгмийн хамгаалалтай холбоотой журмуудын эмхтгэл 2010 он.</p>